

**АГУУЛГА**

<b>1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	3
<b>2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН</b> .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.5 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл .....	9
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b> .....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	12
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл .....	14
3.6 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл .....	15
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН</b> .....	17
4.1 Ерөнхий зүйл .....	17
4.2 Материаллаг байдал .....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	18
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хэрэгжилт .....	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	19
4.5.1 Завсрын аудитын талаар .....	19
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн .....	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	20
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	21
5.1 Албан шаардлага .....	21
5.2 Зөвлөмж .....	23
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	25

**Товчилсон үгийн жагсаалт**

ААНБООАТ	Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар
АДБООУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АНУ	Америкийн нэгдсэн улс
АТҮТ	Авто тээврийн үндэсний төв
БНМАУ	Бүгд найрамдах монгол ард улс
ЗТХЯ	Зам тээвэр хөгжлийн яам
ИНЕГ	Иргэний нисэхийн ерөнхий газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НУБИА	Нью Улаанбаатар Интернэйшнл Аэропорт
ХНН	Хувь нийлүүлсэн нөхөрлөл
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



МИАТ ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ Т.ТЭЛМЭН ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.16 № 734

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу МИАТ ТӨХК -ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн нөлөөг эс тооцвол МИАТ ТӨХК 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүхий л материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 178,435.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Тайлант оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд баталсан орлогын төлөвлөгөө 98,167.9 сая төгрөгөөр тасарч, 32,841.3 сая төгрөгийн алдагдалтай ажилласан;
- 2008-2023 онд үүссэн 22 харилцагчийн 5,783.9 сая төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй, он дамжин үлдэгдэлтэй хэвээр найдваргүй авлага үүсэх эрсдэлтэй;
- Бараа материалын дансанд 10-с дээш жилийн насжилттай 17 нэр төрлийн 114.5 сая төгрөгийн, 5-10 жилийн насжилттай 18 төрлийн 42.4 сая төгрөгийн, нийт 156.8 сая төгрөгийн ашиглалтгүй нөөц үүссэн.

Дээрх зөрчлүүд нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйл 20.1.3, 21 дүгээр зүйлийн 21.4.2, 24 дүгээр зүйлийн 24.1, хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг”, “тохиолдсон байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

## **Асуудлыг онцолсон хэсэг**

Тус компани нь үйл ажиллагаагаа өргөжүүлэн олон улсын нислэгт Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Шанхай хот, Өвөр Монголын Өөртөө Засах Орны Хөх хот, мөн Сингапур улс руу шууд нислэгийг шинээр нээж, тогтмол нислэг үйлдэж эхэлсэн, мөн орон нутгийн нислэгийн сүлжээг тэлэх хүрээнд Баянхонгор аймгийн чиглэлд нислэг үйлдэж эхэлсэн нь орон нутгийн агаарын тээврийн үйлчилгээ, зорчигч тээврийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн чухал алхам болсон байна.

Үндэсний агаарын тээвэрлэгч "МИАТ" ТӨХК нь Бүгд Найрамдах Өмнөд Судан Улсад явагдаж буй Нэгдсэн Үндэсний Байгууллагын мандаттай энхийг сахиулах "Unmiss" ажиллагаанд үүрэг гүйцэтгэх монгол улсын зэвсэгт хүчний цэргийн багийн бие бүрэлдэхүүнийг 2025 оны 9 дүгээр сард 4 удаагийн нислэгээр тээвэрлэн хүргэсэн байна.

## **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бахрайн улсын Gulf Air компанитай 2025 оны 12 дугаар сараас 2026 оны 5 дугаар сар хүртэл 6 сарын хугацаатай нойтон түрээсийн гэрээг байгуулж, В787 агаарын хөлгийг түрээслэх болсоноор 10,424.3 сая төгрөгийн орлого, мөн агаарын хөлгийн техник үйлчилгээний инженерүүд гадаадын 12, дотоодын 17 компанид техник үйлчилгээг үзүүлж 6,963.0 сая төгрөгийн орлогыг тус тус бүрдүүлсэн байна.

Тайлант онд EI-MGL агаарын хөлгийн хөдөлгүүрт их засвар хийж 32,800.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын зардал гаргасан байна.

## **Бусад асуудлын хэсэг**

Тус компани нь 4,341 нислэг үйлдсэн нь өмнөх оноос 25.0 хувиар, 1,184,973 зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 72.0 хувиар тус тус өссөн ба нийт 28,971 тн ачаа, тээш, шуудан тээвэрлэсэн байна.

Дундаж суудал ашиглалт хамгийн өндөр нь Сөүл, Хонгконг, Бээжин чиглэлд 82.0-84.0 хувь байгаа бол хуваарьт нислэгийн дундаж суудал ашиглалт 77.0 хувь, орон нутгийн чиглэлийн дундаж суудал ашиглалт 69.0 хувь, захиалгат нислэгийн хувьд Ханбумбат чиглэлд 92.0 хувь, олон улсын захиалгат нислэг 58.0 хувьтай байна.

## **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12 сарын 31 өдөр	2025 оны 12 сарын 31 өдөр
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	29,414,101,192.54	23,792,384,029.39
1.1.2	Дансны авлага	54,902,233,958.06	56,473,285,924.64
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	21,047,959,798.33	44,592,975,892.91
1.1.4	Бусад авлага	1,722,187,808.33	3,372,806,582.62
1.1.6	Бараа материал	59,711,915,244.80	71,853,492,383.00
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	31,252,130,804.07	26,419,443,828.31
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	198,050,528,806.13	226,504,388,640.87
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	266,080,212,498.42	255,251,412,461.27
1.2.2	Биет бус хөрөнгө	5,953,316,994.62	5,659,780,448.80
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	20,018,150,704.87	20,018,150,704.87
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	566,131,022,675.78	487,051,711,256.29
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	858,182,702,873.69	767,981,054,871.23
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,056,233,231,679.82</b>	<b>994,485,443,512.10</b>
<b>2</b>	<b>Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч</b>		
<b>2.1</b>	<b>ӨР ТӨЛБӨР</b>		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	71,338,128,268.53	95,760,396,486.51
2.1.1.2	Цалингийн өглөг	1,298,490,218.00	116,440,983.00
2.1.1.3	Татварын өр	18,591,429,865.24	39,060,536,687.44
2.1.1.4	НДШ-ийн өглөг	0.00	1,655,766,283.79
2.1.1.5	Богино хугацаат зээл	37,749,988,000.00	26,824,908,454.74
2.1.1.6	Хvүний өглөг	270,241,012.95	181,796,852.25
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	87,644,788,258.50	138,244,443,943.97
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	855,483,353.39	1,107,040,903.03
2.1.1.12	Богино хугацаат түрээсийн өр	71,486,418,163.07	87,050,012,165.63
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	289,234,967,139.68	390,001,342,760.36
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.2.1	Урт хугацаат зээл	19,999,996,000.00	600,122,001.43
2.1.2.4	Бусад урт хугацаат өглөг	4,085,218,849.71	4,124,652,729.75
2.1.2.5	Урт хугацаат түрээсийн өр	457,738,181,903.93	370,045,857,815.24
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	481,823,396,753.64	374,770,632,546.42
<b>2.2</b>	<b>ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН</b>	<b>771,058,363,893.32</b>	<b>764,771,975,306.78</b>
<b>2.3</b>	<b>2. Эзэмшигчдийн өмч</b>		
2.3.1	Өмч : а) төрийн	5,577,283,000.00	5,577,283,000.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	10,585,133,420.50	10,585,133,420.50
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	132,255,956,516.19	132,282,148,516.19
2.3.9	Хуримтлагдсан ашиг	136,756,494,849.81	81,268,903,268.63
2.3.11	Эздийн өмчийн дүн	285,174,867,786.50	229,713,468,205.32
<b>2.4</b>	<b>Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>1,056,233,231,679.82</b>	<b>994,485,443,512.10</b>

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12 сарын 31 өдөр	2025 оны 12 сарын 31 өдөр
<b>1</b>	<b>Борлуулалтын орлого(цэвэр)</b>	<b>941,183,631,669.56</b>	<b>1,006,464,812,659.56</b>
2	Борлуулалтын өртөг	829,564,519,196.20	933,227,641,354.09
<b>3</b>	<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>111,619,112,473.36</b>	<b>73,237,171,305.47</b>
4	Түрээсийн орлого	26,959,199.40	90,481,166.18
5	Хүүний орлого	1,496,041,692.97	209,041,063.69
8	Бусад орлого	6,088,942,753.65	488,252,565.35
9	Борлуулалт, маркетингийн зардал	592,220,355.42	411,106,633.22
10	Ерөнхий ба удирдлагын зардал	40,231,885,536.48	48,806,208,279.33
11	Санхүүгийн зардал	48,995,879,462.92	50,719,535,156.32
12	Бусад зардал	129,869,442.31	371,811,458.12
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз(гарз)	(6,247,467,280.67)	(6,536,681,051.75)
<b>18</b>	<b>Татвар төлөхийн Өмнөх ашиг(алдагдал)</b>	<b>23,033,734,041.58</b>	<b>(32,820,396,478.05)</b>
19	Орлогын татварын зардал	10,550,953,531.79	20,904,106.37
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг(алдагдал)</b>	<b>12,482,780,509.79</b>	<b>(32,841,300,584.42)</b>
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)</b>	<b>12,482,780,509.79</b>	<b>(32,841,300,584.42)</b>
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
<b>24</b>	<b>Орлогын нийт Дүн</b>	<b>12,482,780,509.79</b>	<b>(32,841,300,584.42)</b>
<b>25</b>	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>	<b>12,482,780,509.79</b>	<b>(32,841,300,584.42)</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1	Мөнгөн орлогын дүн	965,182,408,246.42	1,094,202,532,553.52
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	959,955,272,640.84	1,082,436,676,821.63
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	3,606,699,944.37	10,776,213,746.25
1.1.6	Бусад мөнгөн орлого	1,620,435,661.21	989,641,985.64
1.2	Мөнгөн зарлагын дүн	974,219,437,019.79	1,058,017,315,163.60
1.2.1	Ажиллагчдад төлсөн	76,008,827,012.56	84,459,961,645.35
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	19,871,328,821.95	18,555,052,200.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	11,397,964,486.24	14,729,185,370.79
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	300,148,464.49	1,580,617,451.36
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	388,025,141,968.62	427,905,204,053.54
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	3,481,341,415.49	5,070,149,303.32
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	16,258,233,685.34	23,060,056,701.95
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	11,656,494,675.99	10,380,915,568.52
1.2.9	Бусад мөнгөн зарлага	447,219,956,489.11	472,276,172,868.77

<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ дүн</b>	<b>(9,037,028,773.37)</b>	<b>36,185,217,389.92</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
2.1	Мөнгөн орлогын дүн	29,296,997,077.70	209,041,063.69
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	2,036,264,329.00	209,041,063.69
2.1.8	Хадгаламжийн бууралт	27,260,732,748.70	0.0
2.2	Мөнгөн зарлагын дүн	9,128,909,646.38	9,468,379,290.70
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	8,160,980,232.38	9,468,379,290.70
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	967,929,414.00	0.0
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>20,168,087,431.32</b>	<b>(9,259,338,227.01)</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
3.1	Мөнгөн орлогын дүн	40,000,000,000.00	20,000,000,000.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	40,000,000,000.00	20,000,000,000.00
3.2	Мөнгөн зарлагын дүн	40,831,025,083.16	52,821,509,644.17
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	38,204,899,993.16	50,324,953,544.17
3.2.4	Төлсөн ногдол ашиг	2,626,125,090.00	2,496,556,100.00
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(831,025,083.16)</b>	<b>(32,821,509,644.17)</b>
4	Валютын ханшийн зөрүү	(1,176,747,579.59)	273,913,318.11
<b>4.1</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>9,123,285,995.20</b>	<b>(5,621,717,163.15)</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>20,290,815,197.34</b>	<b>29,414,101,192.54</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>29,414,101,192.54</b>	<b>23,792,384,029.39</b>

**2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	<b>2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>5,577,283,000.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>10,585,133,420.50</b>	<b>0.00</b>	<b>2,376,716,050.49</b>	<b>115,997,006,776.43</b>	<b>134,536,139,247.42</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга							8,276,707,563.59	8,276,707,563.59
3	<b>Залруулсан Үлдэгдэл</b>	<b>5,577,283,000.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>10,585,133,420.50</b>	<b>0.00</b>	<b>2,376,716,050.49</b>	<b>124,273,714,340.02</b>	<b>142,812,846,811.01</b>
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	12,482,780,509.79	12,482,780,509.79
6	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00	129,879,240,465.70	0.00	129,879,240,465.70
9	<b>2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>5,577,283,000.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>10,585,133,420.50</b>	<b>0.00</b>	<b>132,255,956,516.19</b>	<b>136,756,494,849.81</b>	<b>285,174,867,786.50</b>
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга							(20,149,734,896.76)	(20,149,734,896.76)
11	<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>5,577,283,000.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>10,585,133,420.50</b>	<b>0.00</b>	<b>132,255,956,516.19</b>	<b>116,606,759,953.05</b>	<b>265,025,132,889.74</b>
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	(32,841,300,584.42)	(32,841,300,584.42)
14	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00	26,192,000.00	0.00	26,192,000.00
15	Зарласан ноогдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	(2,496,556,100.00)	(2,496,556,100.00)
17	<b>2025 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>5,577,283,000.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>10,585,133,420.50</b>	<b>0.00</b>	<b>132,282,148,516.19</b>	<b>81,268,903,268.63</b>	<b>229,713,468,205.32</b>

2.5 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөг/

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 оны гүйцэтгэл	2025оны		Харьцуулалт			
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2024 гүйц/ 2025 гүйц	Хувь	2025 төл/ 2025 гүйцэт	Хувь
1. Зорчигч тээвэрлэлт	мян.хүн	1,153.1	1,274.2	1,196.7	43.6	103.8	(77.5)	93.9
Тогтмол нислэгийн зорчигч тээвэрлэлт	мян.хүн	888.1	1,059.5	957.1	69.0	107.8	(102.4)	90.3
Захиалгат нислэгийн зорчигч тээвэрлэлт	мян.хүн	265.0	214.7	239.6	(25.4)	90.4	24.9	111.6
2. Ачаа тээвэрлэлт (шуудан+ачаа)	тонн	12,589.2	14,840.0	11,347.5	(1,241.7)	90.1	(3,492.5)	76.5
3. Зорчигч эргэлт	сая.хүн.км	2,751.5	3,344.6	3,045.1	293.6	110.7	(299.5)	91.0
4. Ачаа эргэлт	сая.тн.км	49.3	48.5	46.3	(3.0)	93.9	(2.2)	95.5
5. Шилжүүлсэн тонн-километр	сая.тн.км	310.7	396.7	336.3	25.6	108.2	(60.4)	84.8
6. Нийт орлого	мян.төг	948,795,600.0	1,105,420,500.0	1,007,252,600.0	58,457,000.0	106.2	(98,167,900.0)	91.1
Агаарын тээврийн үндсэн үйл ажиллагааны орлого	мян.төг	868,718,900.0	1,056,543,800.0	947,863,300.0	79,144,400.0	109.1	(108,680,500.0)	89.7
Үндсэн бус болон үйл ажиллагааны бус орлого	мян.төг	80,076,700.0	48,876,800.0	59,389,300.0	(20,687,400.0)	74.2	10,512,500.0	121.5
7. Нийт зардал	мян.төг	925,761,800.0	1,091,797,700.0	1,040,073,000.0	114,311,200.0	112.3	(51,724,700.0)	95.3
7.1. Агаарын тээврийн үндсэн үйл ажиллагааны зардал	мян.төг	913,918,100.0	1,079,006,200.0	1,029,326,600.0	115,408,500.0	112.6	(49,679,600.0)	95.4
7.1.1 Үндсэн үйл ажиллагааны зардал	мян.төг	872,513,500.0	1,032,664,400.0	976,879,700.0	104,366,200.0	112.0	(55,784,700.0)	94.6
7.1.2. Ерөнхий удирдлага, нэмэгдэл зардал	мян.төг	41,404,600.0	46,341,800.0	52,446,900.0	11,042,300.0	126.7	6,105,100.0	113.2
ерөнхий нэмэгдэл зардал (захиргаа, удирдлага)	мян.төг	34,669,400.0	38,828,600.0	36,724,700.0	2,055,300.0	105.9	(2,103,900.0)	94.6
зээлийн хүү	мян.төг	3,506,100.0	4,513,200.0	4,981,700.0	1,475,600.0	142.1	468,500.0	110.4
үндсэн хөрөнгийн элэгдэл (аг.хөлгөөс бусад)	мян.төг	3,229,100.0	3,000,000.0	10,740,500.0	7,511,400.0	332.6	7,740,500.0	358.0
7.2 Үндсэн бус болон үйл ажиллагааны бус зардал	мян.төг	5,596,300.0	8,291,500.0	4,209,700.0	(1,386,600.0)	75.2	(4,081,800.0)	50.8
Үндсэн ажиллагааны ашиг (алдагдал) валютын ханшийн алдагдлыг оруулахгүйгээр		29,281,200.0	18,123,000.0	(26,238,700.0)	(55,519,900.0)	(89.6)	(44,361,700.0)	(144.8)
Валютын ханшийн зөрүүгийн бодит олз, гарзын хэлбэлзлийн дүн	мян.төг	2,106,600.0	0.0	9,014,000.0	6,907,400.0	427.9	9,014,000.0	100.0

МИАТ ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Валютын ханшийн зөрүүгийн бодит бус олз, гарзын хэлбэлзлийн дүн		4,140,800.0	4,500,000.0	(2,477,000.0)	(6,617,800.0)	(59.8)	(6,977,000.0)	(55.0)
8. Татварын өмнөх ашиг (алдагдал)		23,033,700.0	13,622,850.0	(32,820,400.0)	(55,854,100.0)	(142.5)	(46,443,250.0)	(240.9)
Татвар тооцогдох үйл ажиллагааны ашиг (алдагдал)		27,174,600.0	18,122,900.0	(35,297,800.0)	(62,472,400.0)	(129.9)	(53,420,700.0)	(194.8)
9. Орлогын албан татвар	мян.төг	10,551,000.0	4,080,700.0	20,900.0	(10,530,100.0)	0.2	(4,059,800.0)	0.5
10. Цэвэр ашиг / (алдагдал)		12,482,800.0	9,542,000.0	(32,841,300.0)	(45,324,100.0)	(263.1)	(42,383,300.0)	(344.2)
11. Төсвийн нийт төлбөр	мян.төг	55,325,100.0	25,353,000.0	44,899,700.0	(10,425,400.0)	81.2	19,546,700.0	177.1
12. Төрийн өмчийн ногдол ашиг	мян.төг	0.0	500,000.0	2,496,600.0	2,496,600.0	100.0	1,996,600.0	499.3
13. Орлогын 1 төгрөгт ногдох зардал	мян.төг	980.0	990.0	1,030.0	50.0	105.1	40.0	104.0
14. Авлага	мян.төг	59,585,500.0	87,388,800.0	104,502,600.0	44,917,100.0	175.4	17,113,800.0	119.6
15. Өглөг	мян.төг	588,470,500.0	808,185,800.0	797,345,100.0	208,874,600.0	135.5	(10,840,700.0)	98.7
Богино хугацаат өглөг	мян.төг	227,300,000.0	328,213,400.0	426,699,100.0	199,399,100.0	187.7	98,485,700.0	130.0
Урт хугацаат өглөг	мян.төг	361,170,500.0	479,972,400.0	370,646,000.0	9,475,500.0	102.6	(109,326,400.0)	77.2
16. Хөрөнгө оруулалт	мян.төг	17,600,300.0	43,984,700.0	16,347,700.0	(1,252,600.0)	92.9	(27,637,000.0)	37.2
17. Ажилчдын тоо	хүн	1,058,000.0	1,381,000.0	1,381,000.0	323,000.0	130.5	0.0	100.0
18. Цалингийн сан	мян.төг	77,806,000.0	83,309,000.0	85,326,000.0	7,520,000.0	109.7	2,017,000.0	102.4
19. Дундаж цалин	мян.төг	6,128,000.0	5,027,000.0	5,149,000.0	(979,000.0)	84.0	122,000.0	102.4

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

МИАТ ТӨХК нь Нисэхийн аюулгүй ажиллагааны шаардлага стандартыг чандлан мөрдөж, үйлчилгээг тогтмол чанартай, найдвартай гүйцэтгэж, өрсөлдөх чадвартай, хүлээн зөвшөөрөгдсөн Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний Монгол улсын үндэсний агаарын тээвэрлэгч компани юм.

Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлээ “Олон улсын болон орон нутгийн шугамын үйлчилгээнд иргэний тогтмол болон тогтмол бус нислэг үйлдэх явдал бөгөөд үйл ажиллагааны үндсэн чиглэлдээ нийцүүлэн хууль тогтоомжоор хориглоогүй, орлого, ашгаа нэмэгдүүлэхэд чиглэгдсэн бизнесийн бусад үйл ажиллагааг эрхэлж болно” гэж тодорхойлсон бөгөөд доорх зорилтын хүрээнд ажилладаг байна. Үүнд:

- Гадаад улсаас ирэх жуулчдын урсгалыг нэмэгдүүлэх зорилгоор Монголын Аялал жуулчлалын холбоотой хамтран ажиллах санамж бичиг байгуулах ажлын хүрээнд Монгол улсад ирэх гадаадын жуулчдад зориулсан тусгай тарифын гэрээ байгуулна;
- Бизнес зэрэглэлийн “MICE” (Meetings Incentives Conferencing Exhibitions) аяллын хөтөлбөрийг дэмжиж Бизнес аялагчдыг нэмэгдүүлэхэд Нийслэлийн аялал жуулчлалын газар, Монголын үндэсний аялал жуулчлал, төрийн бус байгууллага гэх мэт энэ чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлнэ;
- Зочид буудлуудын холбоод төрийн бус байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэн, гишүүн олон улсын сүлжээ Кемпински, Новотел зэрэг зочид буудлуудтай хамтран ажиллаж Блү Скай Монголиа Лоялти хөтөлбөрөө хөгжүүлнэ;
- Олон улсын Аялал жуулчлалын Төрийн болон хувийн хэвшлийн /Тайландын вант улсын төрийн аялал жуулчлалын газар г.м/ байгууллагуудтай хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ;
- “Улаанбаатар төмөр зам ХНН-тэй хамтын ажиллагааг нэмэгдүүлж “Транс Сибирийн гал тэрэг” аялалд хамтарсан хөтөлбөр гаргах судалгаа хийнэ;
- Өвлийн аялал жуулчлалын урсгалыг нэмэгдүүлэх аливаа хамтын ажиллагааг хөгжүүлнэ.

Тус компани гадаадын 5 авиа компанитай аяллын дугаар хамтран эзэмших гэрээ, 27 авиа компанитай тусгай тарифын (СПА) гэрээ, 33 авиа компанитай интерлайны гэрээтэйгээр хамтын ажиллагаанд тулгуурлан сүлжээгээ өргөтгөх бодлогыг хэрэгжүүлдэг байна.

Тайлант онд үйл ажиллагаагаа өргөжүүлэн Шанхай хотын чиглэл болон Сингапур улс руу мягмар, бямба гарагт тогтмол шууд нислэгүүд үйлдсэн, СЕМ Air компаниас CRJ-700 төрлийн хоёр дахь агаарын хөлгийг хүлээн авсан, UNMISS ажиллагаанд оролцож буй Монгол Улсын Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнийг Өмнөд Судан улс руу тээвэрлэн хүргэсэн, Бахрейн улсын Gulf Air компанитай B787 агаарын хөлгийг түрээслэх нойтон түрээсийн гэрээг байгуулсан, орон нутгийн нислэгийн сүлжээг өргөжүүлж Баянхонгор чиглэлийн нислэгийг шинээр нээсэн, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоог ISO 45001:2018, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд ISO 37001:2025 стандартын шаардлагад нийцүүлэн менежментийн тогтолцоог тус тус нэвтрүүлсэн байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

“Монголын иргэний агаарын тээвэр” ТӨХК нь БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1956 оны 6 дугаар сарын 01-ний өдрийн 272 дугаар тогтоолоор үүсгэн байгуулагдаж, Төрийн өмчийн хорооны 2001 оны 442 дугаар тогтоолоор “Төрийн өмчит хувьцаат компани” болж өөрчлөгдсөн байна.

Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Татварын ерөнхий хууль;
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль,

- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- Хөдөлмөрийн тухай хууль.

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Санхүүгийн дотоод аудитын алба нь тайлант онд 37 аудитыг гүйцэтгэхээр төлөвлөснөөс төлөвлөгөөт 26, төлөвлөгөөт бус 5 аудитыг гүйцэтгэн, 992.7 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, аудитын 9, үзлэгийн 15 тайлангаар 90 зөвлөмж өгч ажилласан байна. Гүйцэтгэсэн аудитын үр дүнд дутагдсан бэлэн мөнгө 308.2 сая төгрөгийг буцаан төлүүлж, гадаад сургалтын зардал, бараа материалын тооллогын илүүдэл, анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээ, дүрэмт хувцасны ашиглалтын талаар зөвлөмж өгснөөс хэрэгжилт 94.3 хувь гэж дүгнэсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар бэлэн мөнгөний хяналтын тооллого, гадаад сургалт, маягтын бүртгэлд хийсэн шалгалтыг аудитад ашиглаагүй болно.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Монголын иргэний агаарын тээвэр ТӨХК-ийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, СТОУС, НББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үндсэн зарчмуудад нийцүүлэн нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Монголын иргэний агаарын тээвэр ТӨХК нь СТОУС, НББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нийцүүлэн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн компанийн үйл ажиллагааны онцлогт тохируулан шинэчлэн боловсруулж, гүйцэтгэх захирлын 2022 оны А/33 дугаар тушаалаар батлан мөрдөж байна.

Гүйцэтгэх захирлын 2025 оны А/432 дугаар тушаалаар бараа материал, үндсэн хөрөнгийн тусгай бодлого болон нягтлан бодох бүртгэлийн тусгай бодлогод өөрийн үйл ажиллагаанд нийцүүлэн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулсан байна.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Монголын иргэний агаарын тээвэр ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө, өр төлбөр 994,485.4 сая төгрөгт хүрч, өмнөх оноос 61,747.8 сая төгрөгөөр буюу 5.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	198,050.5	226,504.4	28,453.9
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	29,414.1	23,792.4	(5,621.7)
Дансны авлага	54,902.2	56,473.3	1,571.1

МИАТ ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Татвар, НДШ-ийн авлага	21,048.0	44,593.0	23,545.0
Бусад авлага	1,722.2	3,372.8	1,650.6
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	31,252.1	26,419.4	(4,832.7)
Бараа материал	59,711.9	71,853.5	12,141.6
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>858,182.7</b>	<b>767,981.1</b>	<b>(90,201.6)</b>
Үндсэн хөрөнгө	266,080.2	255,251.4	(10,828.8)
Биет бус хөрөнгө	568,737.9	489,365.0	(79,372.8)
Хойшлогдсон татварын хөрөнгө	20,018.2	20,018.2	0.0
Бусад эргэлтийн бус хөрөнгө	3,346.4	3,346.4	0.0
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,056,233.2</b>	<b>994,485.4</b>	<b>(61,747.8)</b>
<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>771,058.4</b>	<b>764,772.0</b>	<b>(6,286.4)</b>
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>289,235.0</b>	<b>390,001.3</b>	<b>100,766.4</b>
Богино хугацаат зээлийн өглөг	37,750.0	26,824.9	(10,925.1)
Зээлийн хүүгийн өглөг	270.2	181.8	(88.4)
Байгууллагад төлөх өглөг	71,486.4	87,050.0	15,563.6
Татварын өр	18,591.4	39,060.5	20,469.1
НДШ-ийн өглөг	0.0	1,655.8	1,655.8
Дансны өглөг	72,636.6	95,876.8	23,240.2
Урьдчилж орсон орлого	87,644.8	138,244.4	50,599.7
Бусад богино хугацаат өр төлбөр	855.5	1,107.0	251.6
<b>Урт хугацаат өр төлбөр</b>	<b>481,823.4</b>	<b>374,770.6</b>	<b>(107,052.8)</b>
Урт хугацаат зээл	20,000.0	600.1	(19,399.9)
Урт хугацаат түрээсийн өр	457,738.2	370,045.9	(87,692.3)
Бусад урт хугацаат өглөг	4,085.2	4,124.7	39.4
<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>285,174.9</b>	<b>229,713.5</b>	<b>(55,461.4)</b>
Өмч : а) төрийн	5,577.3	5,577.3	0.0
Эздийн өмчийн бусад хэсэг	132,256.0	132,282.1	26.2
Хуримтлагдсан ашиг	136,756.5	81,268.9	(55,487.6)
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	10,585.1	10,585.1	0.0
<b>Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>1,056,233.2</b>	<b>994,485.4</b>	<b>(61,747.8)</b>

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, богино хугацаат өр төлбөр, урт хугацаат өр төлбөр, хуримтлагдсан үр дүнгийн данснуудад өмнөх оны үзүүлэлтээс дараах материаллаг өөрчлөлттэй байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 23,792.4 сая төгрөг болж 5,621.7 сая төгрөгөөр буурсан нь компани нислэгийн үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулах, мөн эргэлтийн хөрөнгийг сайжруулах зорилгоор Хаан банкнаас тухайн ондоо төлөх нөхцөлтэй авсан 10,000.0 сая төгрөгийн зээлийг оны эцэст төлсөн нь голлон нөлөөлсөн;
- Дансны авлагын үлдэгдэл 56,473.3 төгрөг болж 1,571.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь нислэг тээвэрлэлт, тийз борлуулалттай холбоотойгоор агаарын тээврийн компаниуд, ачаа тээврийн болон тийз борлуулалтын агентууд зэрэг харилцагчдаас авах авлагуудын үлдэгдэл нөлөөлсөн;
- Татвар, НДШ-ийн авлагын үлдэгдэл 44,593.0 сая төгрөг болж 23,545.0 сая төгрөгөөс нэмэгдсэн нь агаарын хөлгийн шатахууны 14,171.9 сая төгрөгийн НӨАТ, нисэх буудлын үйлчилгээний 19,386.3 сая төгрөгийн НӨАТ-ын авлагыг нэмж бүртгэсэн нь голлон нөлөөлсөн;
- Бусад /байгууллагаас авах/ авлагын үлдэгдэл 3,372.8 сая төгрөг болж 1,650.6 төгрөгөөр нэмэгдэхэд харилцагч байгууллагуудын бүрэн төлөгдөөгүй өглөг болон үндсэн хөрөнгийн худалдан авалтаас үүссэн хэрэгжээгүй НӨАТ-ын авлагын 1,512.5 сая төгрөг нөлөөлсөн;
- Урьдчилж төлсөн зардал/тооцоо данс 26,419.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Энэ нь Эрчис Ойл ХХК-д 23,021.0 сая төгрөгийн шатахуун нийлүүлснийг урьдчилж төлсөн тооцооны дансанд бүртгэсэн;
- Бараа материалын дансны үлдэгдэл 71,853.5 сая төгрөгт хүрч 12,141.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь нислэгийн аюулгүй байдал, хэвийн явуулах үндсэн шаардлагын улмаас агаарын хөлгийн багаж хэрэгсэл, сэлбэгийг 2,565.3 сая төгрөг, агаарын хөлгийн түлшийг 10,191.2 сая төгрөгөөр нийлүүлсэнтэй холбоотой;

- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 255,251.4 сая төгрөгт хүрч 10,828.8 сая төгрөгөөр буурахад JU-1021 агаарын хөлөгт 1,639.2 сая төгрөгийн хөдөлгүүр, барилга байгууламжид 6,355.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийсэн, үндсэн хөрөнгөд 21,606.0 сая төгрөгийн элэгдэл байгуулсан нь голлон нөлөөлсөн;
- Биет бус хөрөнгийн үлдэгдэл 489,365.0 сая төгрөг болж 70,372.8 сая төгрөгөөр буурсан нь түрээсийн 9 агаарын хөлгийн хөрөнгө ашиглах эрхийн элэгдлийн зардлаар бүртгэсэн;
- Богино хугацаат зээлийн үлдэгдэл 26,824.9 сая төгрөг болж 10,925.1 сая төгрөгөөр буурахад 2024 онд эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх Хаан банкнаас 2 жилийн хугацаатай 40,000.0 сая төгрөгийн зээл, 2025 онд 20,000 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгийн зээлийг тус тус авч, зээлийн эргэн төлөлт хийсэн;
- Зээлийн хүүгийн өглөг 181.8 сая төгрөг болж, 88.4 сая төгрөгөөр буурсан нь арилжааны банкнаас авсан зээлийн хүүг графикайн дагуу төлсөн;
- Байгууллагад төлөх /түрээс/ өглөг 87,050.0 сая төгрөг болж 15,563.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь 2025 оны 8 дугаар сард CRJ-700 агаарын хөлгийг түрээсэлж, өнөөгийн үнэ цэнээр тооцон бүртгэсэн, мөн урт хугацаат өглөгөөс 9 агаарын хөлгийн 2026 оны түрээсийн өглөгийг шилжүүлэн бүртгэсэн;
- Дансны өглөг 95,876.9 сая төгрөг болж, 23,240.3 сая төгрөгөөр нэмэгдэхэд “НУБИА” ХХК-д нисэх буудлын газрын үйлчилгээ /буулт, хөөрөлт/-ний төлбөр 19,171.0 сая төгрөг, Бээжинг евро-ази карго компанийн ачаа тээвэрлэх 7,666.8 сая төгрөгийн өр үүссэнтэй холбоотой;
- Урьдчилж орсон орлого дансны үлдэгдэл 138,244.4 сая төгрөг болж, 50,599.7 сая төгрөгөөр өссөн нь тийзийн борлуулалт болон нисэх буудлуудын хурааж буй зорчигч үйлчилгээний хураамж 26,094.7 сая төгрөг голлон нөлөөлсөн;
- Бусад богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 1,107.0 сая төгрөг болж 251.6 сая төгрөгөөр өссөн нь борлуулалт идэвхжүүлэх зорилгоор Cash and Miles хөтөлбөрийн хүрээнд зорчигчийн билетээс тооцсон урамшууллын 256.6 сая төгрөгийг өглөгөөр бүртгэсэн нь нөлөөлсөн;
- Урт хугацаат зээлийн үлдэгдэл 600.1 сая төгрөг болж 19,399.9 сая төгрөгөөр буурсан нь 2027 оны 1 дүгээр сард төлөх Хаан банкны эргэлтийн хөрөнгийн зээлийн үндсэн төлбөр;
- Урт хугацаат түрээсийн өр дансны үлдэгдэл 370,045.9 сая төгрөг болж 87,692.3 сая төгрөгөөр буурсан нь түрээсийн 9 агаарын хөлгийн төлбөрийг богино хугацаат түрээсийн өглөг рүү бууруулан бүртгэсэн;
- Бусад урт хугацаат өглөгийн үлдэгдэл 4,124.7 сая төгрөг болж 39.4 сая төгрөгөөр өссөн нь гадаадын харилцагч байгууллагаас байршуулсан барьцаа нь гадаад валютын ханшийн өсөлтөөс шалтгаалсан;
- Хуримтлагдсан ашиг дансны үлдэгдэл 81,268.9 сая төгрөг болж 55,487.6 сая төгрөгөөр буурсан нь хуримтлагдсан ашигт тайлант оны 32,841.3 сая төгрөгийн алдагдлыг, ТӨБЗГ-т төлсөн 2024 оны ногдол ашгийн 2,496.5 сая төгрөг, мөн залруулах бичилтээр өмнөх онуудын түрээсийн агаарын хөлөг ашиглах эрхийн хуримтлагдсан элэгдэл 6,379.2 сая төгрөг, өмнөх онуудын татварын төлбөрийн акт 8,181.5 сая төгрөг, АНУ-ын Омни компанитай холбоотой нойтон түрээсийн зардлын 3,464.9 сая төгрөгийг залруулсан нь голлон нөлөөлсөн.

### 3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Монголын иргэний агаарын тээвэр” ТӨХК нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө, техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 732 дугаар тогтоолоор тус компанийн 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг салбарын онцлогт нийцүүлэн, үйлдвэрлэл үйлчилгээний үзүүлэлтүүдээр баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 1,105,420.5 сая төгрөгөөр, нийт зардлыг 1,091,797.7 сая төгрөгөөр, 9,542.0 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар баталсан байна. Хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 43,984.7 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин:

Тус компани гүйцэтгэлээр 1,007,252.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 1,040,073.0 сая төгрөгийн зардал гарган, 32,841.3 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт 1,105,420.5 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 1,007,252.6 сая төгрөг буюу 91.1 хувийн биелэлтэй, 98,167.9 сая төгрөг буюу 8.9 хувиар тасарсан байна. Энэ нь захиалгат нислэгийн орлого 14,587.9 сая төгрөг, нойтон түрээсийн орлого 10,424.3 сая төгрөг, үндсэн бус үйл ажиллагааны орлого 11,300.9 сая төгрөгөөр тус тус давж биелсэн боловч зорчигчтой холбоотой орлого 118,225.9 сая төгрөг, илүү тээшний орлого 1,280.8 сая төгрөг, ачааны орлого 12,453.1 сая төгрөг, шуудангийн орлого 1,732.8 сая төгрөг, үйл ажиллагааны бус 788.4 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Олон улсын зорчигчийн Кореан Эйр, Эйр Чайна, Туркиш Эйрлайнс, Ашиана Эйрлайнс, Жэжү Эйр зэрэг гадаадын 20 гаруй өрсөлдөгч авиа компаниуд зах зээл дээр хямд үнийн бодлогоор өрсөлддөг, ачаа тээврийн агаарын хөлгийн капитал засвар хийгдсэн зэрэг нь орлогын төлөвлөгөө тасрахад тодорхой хэмжээгээр нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 1,040,073.0 сая төгрөг болж, төлөвлөснөөс 51,724.7 сая төгрөг буюу 4.7 хувиар дутуу зарцуулсан байна. Тайлант онд нийт 4,529 удаа нислэг үйлдэхээр төлөвлөсөн ч гүйцэтгэлээр 4,340 удаагийн нислэг үйлдсэнтэй холбоотойгоор үйл ажиллагааны шууд зардлаас шатахууны зардал 21,910.6 сая төгрөгөөр, газрын техник үйлчилгээний зардал 9,152.2 сая төгрөгөөр, агаарын хөлгийн техникийн үйлчилгээ 9,978.5 сая төгрөг, зорчигчийн үйлчилгээний зардал 8,870.2 сая төгрөг, агаарын хөлгийн түрээс 22,138.6 сая төгрөг, нисэх бүрэлдэхүүн, инженер техникийн ажилтнуудын гадаад сургалт, томилолтын зардал 2,333.7 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан байна.

Тайланд онд нийт орлого 98,167.9 сая төгрөгөөр тасарч, 32,820.4 сая төгрөгийн алдагдалтай ажилласан нь компанийн ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлсөн. Тухайлбал орлогын 1 төгрөгт ногдох зардлыг 0.99 төгрөг байхаар төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 1.03 төгрөг болж, 0.04 төгрөгөөр нэмэгдсэн байна.

Байгууллагын мөнгөн хөрөнгө, авлагын үлдэгдэл 16,312.3 сая төгрөгөөр өссөн хэдий ч богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 100,766.4 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотойгоор түргэн хөрвөх чадварын харьцаа өмнөх онд 0.48 байсан бол тайлант онд 0.40 болж буурсан нь компанийн төлбөрийн чадварт сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 6 төрлийн 55 нэрийн ажилд өөрийн эх үүсвэрээс 16,347.7 сая төгрөг буюу 37.2 хувийг зарцуулсан байна.

**Судалгааны үр дүн, нөхцөл байдал**

Тайлант хугацааны төсвийн зарцуулалтын талаарх судалгааны үр дүн дараах байдалтай байна. Үүнд:

1. Байгууллагуудын орон тооны цомхотголын талаар:

Засгийн газрын 2025 оны “Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” 7 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар нийт орон тоог 9.0 хувиар бууруулахаар баталсныг хэрэгжүүлж ажиллаагүй;

2. Унаа, хоолны хөнгөлөлтийн зардлын тарифын талаар:

МИАТ ТӨХК-ийн үйлдвэрчний эвлэлтэй 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдөр байгуулсан 02 дугаартай хамтын гэрээгээр ажилтнуудад олгох сарын хоолны хөнгөлөлтийн хэмжээг 20.0 мянган төгрөгөөр тогтоосныг 2025 оны 12 дугаар сар хүртэл хоолны хөнгөлөлтийг тухайн хэмжээгээр олгосон;

3. Гадаад томилолт, арга хэмжээний судалгааны талаар:

Тайлант онд гадаад албан томилолт, арга хэмжээнд нислэг үйлдвэрлэлтэй холбоотой 1,265,694.7 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс 713.8 сая төгрөгийг зарцуулсан;

4. Сургалт, хурал, зөвлөгөөний судалгааны талаар:

Тайлант онд нисэх бүрэлдэхүүний сургалтын зардалд 9,088.5 сая төгрөгийг, дотоод

сургалтын зардалд 2,400.5 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс нисэх бүрэлдэхүүний сургалтад 6,754.7 сая төгрөгийг дотоод сургалтад 143.7 сая төгрөгийг тус тус зарцуулсан;

**5.Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээ, төлбөрийн талаар:**

Тайлант хугацаанд 23 цахим сайт, 7 телевиз, 3 сонин, сэтгүүл хамрагдан нийт 33 хэвлэл мэдээллийн байгууллагатай гэрээ байгуулж зар сурталчилгааны үйл ажиллагаа хэрэгжүүлсэн бөгөөд дээрх гэрээнүүдийн хүрээнд, нийт 308.1 сая төгрөгийн зардал гаргасан;

**6.Төрийн өмчийн үйлдвэрийн газрын судалгаа:**

Тус төрийн өмчит аж ахуйн нэгжийн батлагдсан орон тоо болон тайлант онд гарсан цалингийн зардлыг ангиллаар авч үзвэл, дээд шатны удирдлагын 15 орон тоонд 1,737.9 сая төгрөг, дунд шатны удирдлагын 27 орон тоонд 3,311.9 сая төгрөг, гүйцэтгэх ажилтны 1,270 орон тоонд 84,600.7 сая төгрөгийн цалингийн зардал тус тус гарсан байна.

**3.6 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

“Монголын иргэний агаарын тээвэр” ТӨХК-ий Төлөөлөн удирдах зөвлөлийн "Компанийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлах тухай" 2025 оны 01/25 дугаар тогтоол, гүйцэтгэх захирлын "Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлах тухай" 2025 оны А/07 дугаар тушаалаар 270,668.2 сая төгрөгийн төсөвтэй 228 худалдан авах ажлыг зохион байгуулахаар төлөвлөсөн байна.

Хүснэгт 2. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлт

/сая төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөөний		Гүйцэтгэлийн			Зөрүү	
		тоо	дүн	тоо	дүн	хувь	тоо	дүн
1	Бараа	157	219,827.1	138	180,435.0	82.1	19	39,392.2
2	Ажил	26	17,148.7	5	72.6	0.4	21	17,076.1
3	Үйлчилгээ	45	33,692.4	13	13,104.3	38.9	32	20,588.1
<b>Дүн</b>		<b>228</b>	<b>270,668.2</b>	<b>128</b>	<b>193,611.8</b>	<b>71.5</b>	<b>72</b>	<b>77,056.4</b>

Гүйцэтгэлээр 193,611.8 сая төгрөгийн 128 худалдан авалтыг зохион байгуулж, 77,056.4 сая төгрөгийн 100 худалдан авалтын ажил хийгдээгүй байна. Энэ нь тендер оролцогчгүй, техникийн тодорхойлолтын, тендерийн ерөнхий болон баримт бичгийн шаардлага хангаагүйгээс сонгон шалгаруулалт амжилтгүй болсон, НУБИА-аас олгох газрын болон тусгай зөвшөөрөлтэй холбоотой барилгын ажлууд хойшлогдож, түүнтэй холбоотой тоног төхөөрөмж, сэлбэг материалын өндөр дүнтэй худалдан авалтууд хийгдээгүй зэргээс шалтгаалсан байна.

Хүснэгт 3. Худалдан авах ажиллагааны хэрэгжилт

/сая төгрөгөөр/

№	Худалдан авалт	Төлөвлөгөөний		Гүйцэтгэлийн			Зөрүү	
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Хувь	Тоо	Мөнгөн дүн
1	Нээлттэй тендер шалгаруулалт	73	80,328.7	64	31,257.9	38.9	9	49,070.8
2	Харьцуулалт	51	3,174.5	28	875.5	27.6	23	2,299.0
3	Гэрээ шууд байгуулах	83	1,474.5	48	657.8	44.6	35	816.7
4	Шууд худалдан авалт	13	184,706.0	10	160,174.5	86.7	3	24,531.6
5	Цаг үеийн шаардлагат захиалгаар шууд худалдан авалт	8	984.5	6	646.2	65.6	2	338.3
<b>Дүн</b>		<b>228</b>	<b>270,668.2</b>	<b>156</b>	<b>193,611.8</b>	<b>71.5</b>	<b>72</b>	<b>77,056.4</b>

Засгийн газрын 2024 оны 2 дугаар тогтоолоор батлагдсан “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” журмын дагуу тайлант онд нээлттэй тендер шалгаруулалтыг 64, харьцуулалтын аргаар 17, шууд гэрээ байгуулах аргаар 14, нэг эх үүсвэрээс худалдан авах аргаар 9 удаагийн давтагдсан тоогоор нийт 145 удаагийн цахим тендер зарлан бараа, ажил, үйлчилгээ худалдан авах нийт 125 гэрээ байгуулсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Монголын иргэний агаарын тээвэр ТӨХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд “Монголын иргэний агаарын тээвэр” ТӨХК, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн компанийн захиалгат нислэгийн орлогын тооцоо, түр албан тушаалтны томилгоо, бараа материал, үндсэн хөрөнгийн ашиглалт, гэрээний хэрэгжилтэд тавих хяналтыг тус тус сайжруулах талаарх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Б.Долгоржав, аудитор Ж.Бямбацогт, Г.Ганбилэг нар гүйцэтгэж, аудитын менежер В.Эрдэнэцогт анхан шатны чанарын хяналтыг, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

“Монголын иргэний агаарын тээвэр” ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 10-ний өдрийн 01/264 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний баталсан төлөвлөгөөний нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний баталсан төлөвлөгөөний нийт зардлын дүн 925,761.8 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 9,257.6 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн өмчтэй компаниудад хамаарах хуулийн 30 заалтын хэрэгжилтийг шалгагдагч байгууллагаас гаргуулж үнэлсэн. Тус компани тайлант онд хэмнэлтийн зарчим барьж хуульд заасан хангамж, үйл ажиллагааны хязгаарлалтыг мөрдөж ажилласнаар 97,553.5 сая төгрөгийг дутуу зарцуулсан байна. Тухайлбал:

- Сургалт, зөвлөгөө, үйлчилгээний зардал 5,954.9 сая төгрөг;
- Зар сурталчилгааны зардал 4,489.1 сая төгрөг;
- Үндсэн үйлчилгээний зардал 10,053.1 сая төгрөг;
- Давхардсан тоогоор нийт 145 удаа Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр дамжуулан тендер шалгаруулалтыг зохион байгуулж, 125 худалдах, худалдан авах гэрээ байгуулснаар 77,056.4 сая төгрөгийг тус тус хэмнэлттэй зарцуулсан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн тасалбарын үнийг хөнгөлсөн, урамшууллын хэмжээтэй холбоотой худалдан авалтын мэдээллийг шилэн дансны цахим хуудаст байршуулаагүй зөрчилд албан шаардлага хүргүүллээ.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулбал зохих нийт 180 мэдээнээс 178 мэдээ, 1,035,950.2 сая төгрөгийн орлогын 10464 ажил гүйлгээг, 1,035,071.6 сая төгрөгийн зарлагын 4431 ажил гүйлгээний мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна. Харин зорчигчийн урсгалыг нэмэгдүүлэх суудал ашиглалтыг сайжруулах зорилгоор тасалбарын үнийг хөнгөлсөн, урамшууллын хэмжээг баталсан, санхүүгийн тайланд залруулга хийх зэрэг тус компанийн гүйцэтгэх захирлын 2025 оны 18 тушаал, хөрөнгө оруулалтаар 32,133.4 сая төгрөгийн таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг зэргийг шилэн дансны цахим хуудаст байршуулаагүй, зөрчил давтагдсан байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудаст хуулийн дагуу мэдээлэл байршуулдаггүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хэрэгжилт

Бусад хууль тогтоомжтой холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Тус компанийн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 87-73УКС /Nissan patrol/, 93-59УБВ /Toyota land cruiser 200/ маркийн 2 автомашин нь цагаан болон цэнхэр өнгийн дэвсгэрт бүхий 2 янзын дугаартай байгаа бөгөөд хяналтын тооллого хийх үед цагаан өнгийн дугаартай байсан нь хөрөнгийг зориулалт бус ашиглах эрсдэлтэй бөгөөд хөрөнгийн бүртгэлээс үзэхэд Бээжин хотын төлөөлөгчийн газарт үндсэн 2 ажилчинтай боловч 3 автомашин, Сөүл хотын төлөөлөгчийн газарт үндсэн 6 ажилчинтай боловч 4 автомашин, Токио хотын төлөөлөгчийн газарт үндсэн 3 ажилчинтай боловч 3 автомашин тус тус ашиглаж байгаа нь хэт үрэлгэн зарцуулалттай байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т *"Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгсэлээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ"*, Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т *"үр ашигтай байх"*, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1.3-т *"үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах"* гэж заасантай тус тус нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: Гадаад дахь төлөөлөгчийн газруудын орон тоо, бүтэц болон тээврийн хэрэгслийн тоо, ашиглалт, хэрэгцээнд судалгаа хийж, илүүдэл, үр ашиггүй автомашиныг татан төвлөрүүлэх, компанид бүртгэлтэй тээврийн хэрэгслийн улсын дугаарыг холбогдох хуулийн шаардлагад нийцүүлэх, зориулалтын бус дугаар ашиглаж буй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлээ.

2. МИАТ ТӨХК-ий Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 13/24 дугаар тогтоолоор орон тооны дээд хязгаарыг баталсан, Гүйцэтгэх захирлын 2016 оны Б/784 дугаар тушаалаар компанийн хэлтэс, нэгжүүдийн бүтэц, зохион байгуулалт, орон тоог баталсанд жил бүр гүйцэтгэх захирлын тушаалаар бүтцийн өөрчлөлт оруулсан байна. Гэхдээ түр албан тушаалд нислэгийн ачаалалтай уялдаагүй, удаан хугацаагаар ажиллуулах, үйлдвэрлэлийн нэгжид бус төв оффист түр албан тушаалтан авах зэргээр орон тоо бүтцийг оновчтой зохион байгуулахгүй байгаа нь цалингийн зардлын өсөлтөд нөлөөлж байна. Энэ нь МИАТ ТӨХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.8.9 *"Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан орон тоо, зохион байгуулалтын бүтцийн хүрээнд ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг батлах, ажилтныг ажилд томилох, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, ажлаас чөлөөлөх"* гэсэн заалттай нийцэхгүй, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: ТӨБЗГ-ын баталсан эдийн засгийн зорилтот түвшинд заасны дагуу

түр ажилтныг нислэгийн ачааллын үетэй уялдуулан ажиллуулах.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн зарим заалттай, бусад нийцлийн асуудалд нь холбогдох хууль тогтоомжийн зарим заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Монголын иргэний агаарын тээвэр” ТӨХК-ийн 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд завсрын аудитаар зорчигч, ачаа, шуудан тээврийн орлого, техник үйлчилгээний орлого, газрын үйлчилгээ, үндсэн хөрөнгө, бараа материалын хөдөлгөөний тушаал шийдвэрийн хэрэгжилт, цалин хөлсний бүртгэл, худалдан авах ажиллагааны үйл ажиллагааны гүйцэтгэл, төлөвлөгөөний биелэлтэд горим, сорил хэрэгжүүлж, нийт 11,553.4 сая төгрөгийн алдаа, зөрчлийг илрүүлэн шалгагдагч байгууллагад танилцуулан, 957.4 сая төгрөгийн 6 алдааг залруулах, зөрчлийг давтан гаргахгүй байх 10,596.0 сая төгрөгийн зөрчилд 9 зөвлөмжийг өгсөн.

Жилийн эцсийн аудитаар дахин хянахад 957.4 сая төгрөгийн 6 алдааг залруулж, 6 10,596.0 сая төгрөгийн 6 зөвлөмж хэрэгжсэн байна. Хэрэгжээгүй 3 зөвлөмжид албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар нийт 10 алдаа, зөрчил илэрснээс 5,015.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах 7 албан шаардлага хүргүүлж, 226.7 сая төгрөгийн 3 зөвлөмж өгсөн. Тус компанийн гүйцэтгэх захирлын 2025 оны А/164 дүгээр тушаалаар өмнөх аудитын шийдвэрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг гаргаж баталсан байна.

Тус компанийн 2025 оны 01/2203 дугаар албан бичгээр өмнөх аудитын шийдвэрийн биелэлтийг гаргаж ирүүлснийг тулган шалгахад 226.7 сая төгрөгийн 3 зөвлөмж бүрэн хэрэгжиж, 5,015.6 сая төгрөгийн 7 албан шаардлагаас 5 албан шаардлага бүрэн хэрэгжиж, 2 албан шаардлага хэрэгжээгүй, 66.4 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	3	226.7	3	226.7	100.0
Албан шаардлага	7	5,015.6	5	1,652.8	32.9
<b>Нийт дүн</b>	<b>10</b>	<b>5,242.3</b>	<b>8</b>	<b>1,879.5</b>	<b>66.4</b>

Цалингийн зардлыг төлөвлөгөөнөөс хэтрүүлэн зарцуулсан, авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь байршуулаагүй зөрчилд өгсөн 3 албан шаардлага хэрэгжээгүй байна.

Тус компанийн удирдах бүрэлдэхүүнд өөрчлөлт орсноос өмнөх оны аудитаар өгсөн 3 албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцох боломжгүй тул шинээр томилогдсон удирдлагын багт хариуцуулан зөрчил арилгах албан шаардлагыг дахин хүргүүллээ.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дээд шатны байгууллагын анхааралд хандуулах дараах асуудлууд байна: Үүнд

- Олон Улсын Зорчигч тээврийн онгоцны билетийн бичилтийг орлого хяналтын EDGAR программаар хянаж, санхүүгийн программд бүртгэхдээ сар бүр орлогын тулгалт хийж тооцоо бодсон эсэх, нислэгийн чиглэл өөрчлөгдсөн, билетийн буцаалтын орлого зэргийг нягтлан шалгах;
- Тус компанийн захирлын зөвшөөрлөөр онгоцны билетийн үнийг 100 хувь хөнгөлөх Эрхийн бичгийг олгох үндэслэл, зохицуулах журмыг боловсруулж мөрдсөн эсэх;
- Татварын ерөнхий газрын Том татвар төлөгчдийн газрын Хяналт шалгалтын хэлтсээс

2021-2023 оны санхүүгийн баримтад хийсэн шалгалтаар татварын улсын байцаагчийн тавьсан төлбөрийн актаас нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийн хэрэгжилттэй холбоотой 32,704.3 сая төгрөгийн нөхөн ногдуулалт, торгуулийг бодит нөхцөл байдалд нийцсэн эсэхийг нягтлан шалгуулахаар Татварын маргаан таслах зөвлөлд хандсан байгаа тул НББОУС-37 дагуу аудитын тайланд толилуулсан байгааг анхаарч дараагийн аудитаар шалгах хэрэгтэй.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 99,129.8 сая төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 99,129.8 сая төгрөгийн алдааг залрууллаа.

*Залруулсан алдаа:*

- interlain зорчигч, тээшний орлогыг 160.8 сая төгрөгөөр илүү бүртгэсэн;
- Нью жуулчин турс ХХК-ын захиалгат нислэгийн 65.0 сая төгрөгийн орлогыг зөрчигч тээврийн өр дансанд, илүү тээшний 2.3 сая төгрөгийн орлогыг агаарын тээврийн өр дансанд тус тус буруу бүртгэсэн;
- Өмнөх онд шатахууны зардлаар бүртгэсэн 123.4 сая төгрөгийн залруулгыг хийхдээ хуримтлагдсан үр дүнг бууруулаагүй, тайлант оны шатахууны зардлыг бууруулж буруу бүртгэсэн;
- 2021-2023 оны санхүүгийн баримтанд хийсэн татварын шалгалтаар тавьсан төлөрийн актын 40,754.6 сая төгрөгөөр тайлант үеийн ашгийг бууруулж буруу бичилт хийсэн;
- Цалингийн урьдчилгаа 22,489.9 сая төгрөг, урьдчилгаа төлбөрт 4,327.2 сая төгрөг, нийт 26,814.1 сая төгрөгийг олгоод урьдчилж төлсөн зардлын тооцоо үүсгээгүй, өглөгийн дансанд бүртгэсэн;
- Бахрейн улсын Gulf air BSC компанитай Boeing B787-9 EI-MGL агаарын хөлгийн нойтон түрээсийн гэрээний урьдчилж орсон орлогыг өглөг дансанд бүртгэсэн;

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын толилуулга батламж мэдэгдлийг хангаагүй.

Аудитаар нийт 125,249.5 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрсэнд, 124,884.4 сая төгрөгийн 11 зөрчилд албан шаардлага өгч, 365.1 сая төгрөгийн 5 зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 125,249.5 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 114,389.2 сая төгрөгөөр давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

### 5.1 Албан шаардлага

1. Өмнөх онуудад үүссэн 22 харилцагчтай холбоотой 5,783.9 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг барагдуулах арга хэмжээ аваагүй, он дамжин үлдэгдэлтэй хэвээр байж, найдваргүй авлага үүсэх эрсдэлтэй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8-д “өр авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Олон жилийн насжилттай авлагыг барагдуулаагүй зөрчлийг 30.0 хүртэл хувиар бууруулах, албан шаардлага хүргүүлээ.

2. Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн авлагын үлдэгдэл 16,442.6 сая төгрөг, өглөгийн үлдэгдэл 1,785.8 сая төгрөг, нийт 14,656.8 сая төгрөгийн үлдэгдлийг жилийн эцэст тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй, зөрчил давтагдсан байна.

Шийдвэрлэсэн нь: Жилийн эцэст авлага, өглөгийн үлдэгдлийг харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчлийг таслан зогсоох албан

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

шаардлага хүргүүлээ.

3. Бараа материалын үлдэгдэлд хяналтын тооллого хийхэд ашиглалтын хугацаа нь 2021 оны 7 дугаар сард дууссан 27.9 сая төгрөгийн өртөгтэй 6665 ширхэг ликёрын үлдэгдэлтэй байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д “нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.2-т “төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийн эд хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах талаар санал боловсруулж төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад оруулах” гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Хугацаа нь дууссан, шаардлага хангахгүй бараа материалын нөөц үүсгэсэн зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

4. Өмнөх онд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 3 нэр төрлийн 114 ширхэг үндсэн хөрөнгөд тайлант хугацаанд, нийт 123.4 сая төгрөгийн элэгдлийг тооцож бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “жинхэнэ хэрэгжилтийн”, 5.1.4-т “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгөд элэгдэл байгуулсан зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлээ.

5. Тус байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд түүврийн аргаар хяналтын тооллого хийхэд 6.4 сая төгрөгийн үнэтэй I mac pro-27, 5.6 сая төгрөгийн үнэтэй macbook pro 13.3 inch, нийт 12.0 сая төгрөгийн үнэтэй 2 ширхэг хөрөнгийг ажлаас халагдсан албан тушаалтнаас хүлээж аваагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т “эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед”, 12.4-т “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллага үрэгдүүлж, дутаасан хөрөнгийн тооцоог түүний өртөг болон зах зээлийн үнийн аль өндрөөр хийнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.4-т “нягтлан бодох бүртгэл хөтөлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1-д “өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах” гэсэн заалттай тус тус нийцээгүй.

**Шийдвэрлэсэн нь:** Ажлаас чөлөөлөгдсөн албан тушаалтантай эд хөрөнгийн тооцоог хийж, хөрөнгийг хүлээж аваагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлээ.

6. Тайлант оны 1-9 дүгээр сард 9 аж ахуйн нэгж байгууллага болон урлаг, соёл, спортын ажилтнууд зэрэг нийт 452 иргэний билетний үнийг 50-100 хүртэл хувиар буюу 531.3 сая төгрөгийн хөнгөлөлт олгохдоо бартерийн болон хамтран ажиллах гэрээ байгуулаагүй, үр дүнг тооцоогүй, улирал тутам тайлагнаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 3-т “Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын хөрөнгөөр хандив, тусламж, түүнтэй адилтгах аливаа хөтөлбөр, арга хэмжээ, нийгмийн шинжтэй үйл ажиллагаа болон төсвийн алдагдлыг санхүүжүүлэхийг хориглоно”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалттай тус тус нийцээгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Хамтран ажиллах болон бартерийн гэрээ байгуулалгүй хөнгөлөлт үзүүлсэн, үр дүнг тооцоогүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ.

7. Тайлант оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд баталсан орлогын төлөвлөгөө 98,167.9 сая төгрөгөөр тасарч, 32,841.3 сая төгрөгийн алдагдалтай ажилласан бөгөөд борлуулалтын орлогод ногдох бүтээгдэхүүний өртөг 4.6 хувиар өссөн нь ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1.3-т “үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө

боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах” гэсэн заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшинд баталсан орлогын төлөвлөгөөг биелүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэх талаар анхаарч ажиллах албан шаардлага хүргүүлээ.

8. Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчиж, хүлээн авалтын зардалд 4.8 сая төгрөгийг төлж, зарлагын баримтын бүрдэлгүй, үрэлгэн зарцуулсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “13.7.Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 01 тоот албан даалгаврын 2.6-д “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн үрэлгэн байдал, хэрэгцээгүй худалдан авалт, гадаад томилолтыг хязгаарлаж, тансаглалыг таслан зогсоох талаар харьяа байгууллага, хуулийн этгээдийн удирдлагад үүрэг өгч, үр дүнг тооцож ажиллах” гэсэн заалттай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны бүрдэл дутуу баримтаар зарлагын гүйлгээ хийж үрэлгэн зарцуулсан зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ.

9. Гүйцэтгэх захирлын 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн А/52 дугаар тушаалаар ахмадын санд шилжүүлж “Монгол Улсад Нисэх хүчин үүсэж хөгжсөний түүхт 100 жилийн ойд зориулан ном эмхэтгэн гаргахад 25.0 сая төгрөг, баримтат кино бүтээхэд зориулж 40.0 сая төгрөгийг төлж, зориулалт бус, үрэлгэн зарцуулсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4-д “Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх”, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт “Ахмадын санг байгуулан ажиллуулах” журмын 3.4-т “Ахмадын сангийн хөрөнгийг зориулалтын бус зүйлд ашиглах, зарцуулахыг хориглоно” гэсэн заалттай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын төсвийн хөрөнгөөр Төрийн хэмнэлтийн хуулиар хориглосон үйл ажиллагааг санхүүжүүлсэн зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ.

10. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 732 дугаар тогтоолоор МИАТ ТӨХК-ийн 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг, МИАТ ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 13/24 дүгээр тогтоолоор 2025 оны цалингийн санг 87,712.1 сая төгрөгөөр баталсан байна. Тайлант онд нислэг-үйлдвэрлэлийн үйл ажиллагааны ажилчдын цалинг 1,814.3 сая төгрөг, ерөнхий удирдлагын зардлын цалин 1,078.7 сая төгрөгөөр тус тус хэтрүүлж, зөрчил давтагдсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4-т “үйлдвэрийн газрын захиргааны бүтцийг тогтоож, албан тушаалтныг томилох, чөлөөлөх, эрх бүхий байгууллагаас тогтоосон цалингийн бүдүүвч сангийн хэмжээнд багтаан цалинг тогтоох”, МИАТ ТӨХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.8.9-д “Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан орон тоо, зохион байгуулалтын бүтцийн хүрээнд ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг батлах, ажилтныг ажилд томилох, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, ажлаас чөлөөлөх” гэсэн заалттай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд зардлыг бодитой төлөвлөөгүй, цалингийн зардлыг хэтрүүлсэн зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ.

11. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 732 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар үйлдвэрлэлийн нэгжид зуны нислэгээр 283 түр орон тоог баталсан байна. Гүйцэтгэлээр үйлдвэрлэлийн нэгжид хамаарахгүй 11 хэлтэс, нэгжид хөдөлмөрийн гэрээ байгуулан 39 ажилтныг түр томилон ажиллуулж, нийт 832.6 сая төгрөгийн цалин олгож үр ашиггүй зардал гаргасан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн

20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4-т “үйлдвэрийн газрын захиргааны бүтцийг тогтоож, албан тушаалтныг томилох, чөлөөлөх, эрх бүхий байгууллагаас тогтоосон цалингийн бүдүүвч сангийн хэмжээнд багтаан цалинг тогтоох”, МИАТ ТӨХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.8.9-д “Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан орон тоо, зохион байгуулалтын бүтцийн хүрээнд ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг батлах, ажилтныг ажилд томилох, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, ажлаас чөлөөлөх” гэсэн заалттай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан орон тоонд байхгүй үйлдвэрлэлийн бус нэгжид түр ажилтан томилон ажиллуулсан зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ.

## 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэв. Үүнд:

### 1. Авлага, өглөгийн тооцооны дантай холбоотой асуудал

Үлэмж Эс Жи Жи катеринг ХХК-тай “Агаарын хөлгөөр зорчигчдын хоол бэлтгэн нийлүүлэх” 24/352 дугаартай гэрээг 2024 оны 9 дугаар сарын 20-ны өдөр 1 жилийн хугацаатай гэрээний хугацаа дуусгавар болж, нээлттэй тендер сонгон шалгаруулалтыг зарлаж 3 компани оролцож шаардлага хангаагүй гэж үзэж, Үлэмж Эс Жи Жи катеринг ХХК-тай 2025 оны 10 дугаар сарын 02-ны өдөр нэмэлт гэрээ байгуулахдаа бизнес ангиллын зорчигчдын хоолны бохирын угаалгын зардал, ус ундаа тээвэрлэлтийн зардлыг тооцох тооцооллыг тусгаж, хоорондын тооцоо нийлээгүй. Энэ нь Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.5 “Худалдан авах гэрээний үүргийн гүйцэтгэлийн харилцааг хуульд өөрөөр заагаагүй бол Иргэний хуулиар зохицуулна”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үлэмж Эс Жи Жи катеринг ХХК-тай байгуулсан гэрээг дүгнэж, тооцоог нийлж баталгаажуулах.

### 2. Бараа материалын данстай холбоотой асуудал

Бараа материалын дансанд 10-с дээш жилийн насжилттай 17 нэр төрлийн 114.5 сая төгрөгийн, 5-10 жилийн насжилттай 18 төрлийн 42.4 сая төгрөгийн, нийт 156.8 сая төгрөгийн бараа материалын ашиглалтгүй нөөц үүсгэсэн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д “нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх” гэсэн заалттай нийцээгүй, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шаардлагагүй бараа материалыг худалдан авахгүй байх, бүртгэлээр тавих хяналт, ашиглалтыг сайжруулах.

### 3. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үлдэх өртөггүй 10,546.1 сая төгрөгийн 2960 ширхэг хөрөнгийн цаашид ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох хүсэлтийг холбогдох байгууллагад хүргүүлээгүй, ашиглалтыг сайжруулах талаар арга хэмжээ аваагүй байна. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-д “илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох”, ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан журмын 7 дугаар зүйлийн 7.1-д “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт ирүүлж, шийдвэрлүүлнэ” гэсэн заалттай тус тус нийцэхгүй, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлж, ашиглалтыг сайжруулах, үнийг шинэчлэн тогтоох, саналыг

холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлэн шийдвэрлүүлэх.

#### **4. Зардлын данстай холбоотой асуудал**

Өвлийн улиралд дуудлагын бэлэн байдлыг хангах зорилгоор 22 автомашинд 4-6 сарын хугацаатай дулаан зогсоолын гэрээ байгуулж 63.7 сая төгрөг төлснөөс 9 автомашин нэгжийн дуудлагад явдаггүй, газрын дарга нарт үйлчилдэг 9 автомашины дулаан зогсоолын төлбөрт 25.0 сая төгрөг төлж үр ашиггүй зарцуулсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын тэргүүн дэд, дэд, орлогч дарга болон дэд сайд, яамны төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн захирал, төсвийн байгууллагын дарга хот дотор албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно.”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалттай тус тус нийцэхгүй, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Дуудлагаар үйлчилдэггүй автомашинд дулаан зогсоол түрээслэхгүй, Төрийн хэмнэлтийн хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллах.

#### **5. Дотоод хяналттай холбоотой асуудал**

МИАТ ТӨХК-нь баазын тээврийн хэрэгслийн 34 авто машинд GPS суулгасан 16 автомашинд GPS суулгаагүй бөгөөд эдгээр автомашинуудаас 7 авто машин нь албан тушаалын авто машин унах эрхгүй газрын захирлуудад үйлчилж байгаа бөгөөд жолоочийн замын хуудсыг өдөрт 100-140 км явснаар тогтмол бүртгэсэн, нийт 71.8 сая төгрөгийн шатахууны зардал гаргасан байна. Мөн зарим албан тушаалтнуудын хувийн автомашинд 111.4 сая төгрөгийн шатахууныг олгож үрэлгэн зардал гаргасан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын тэргүүн дэд, дэд, орлогч дарга болон дэд сайд, яамны төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн захирал, төсвийн байгууллагын дарга хот дотор албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно.”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалттай тус тус нийцэхгүй, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Албан тушаалын суудлын автомашин унах эрхгүй албан тушаалтан болон хувийн автомашинд шатахуун олгохгүй байх, жолоочийн замын хуудаст, автомашины явсан чиглэл, гүйцэтгэсэн ажил, километрийн заалтыг үнэн зөв бүртгэж, дуудлагын авто машины ашиглалтад тавих дотоод хяналтыг сайжруулах.

Дээрх аудитын шийдвэрийн хэрэгжилтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/сая төгрөгөөр/

№	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу бүртгэсэн илэрхийлэл		Үүнээс					
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Зөвлөмж	
								Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	interlain зорчигч, тээшний орлогыг 160.8 сая төгрөгөөр илүү бүртгэсэн	1	160.8			1	160.8	1	160.8				
2	Нью жуулчин турс ХХК-ын захиалгат нислэгийн 65.0 сая төгрөгийн орлогыг зөрчигч тээврийн өр дансанд, илүү тээшний 2.3 сая төгрөгийн орлогыг агаарын тээврийн өр дансанд тус тус буруу бүртгэсэн	1	67.3			1	67.3	1	67.3				
3	Өмнөх онд шатахууны зардлаар бүртгэсэн 123.4 сая төгрөгийн залруулгыг хийхдээ хуримтлагдсан үр дүнг бууруулаагүй, тайлант оны шатахууны зардлыг бууруулж буруу бүртгэсэн	1	123.4			1	123.4	1	123.4				
4	2021-2023 оны санхүүгийн баримтад хийсэн татварын шалгалтаар тавьсан 40,754.6 сая төгрөгөөр тайлант үеийн ашгийг бууруулж буруу бичилт хийсэн.	1	40,754.6			1	40,754.6	1	40,754.6				
5	Цалингийн урьдчилгаа 22,489.9 сая төгрөг, урьдчилгаа төлбөрт 4,327.2 сая төгрөг, нийт 26,814.1 сая төгрөгийг олгоод урьдчилж төлсөн зардлын тооцоо үүсээгүй, өглөгийн дансыг бууруулж буруу бүртгэсэн.	1	26,814.1			1	26,814.1	1	26,814.1				
6	Бахрейн улсын Gulf air BSC компанитай Boeing B787-9 EI-MGL агаарын хөлгийн нойтон түрээсийн гэрээний урьдчилж орсон орлогыг өглөг дансанд бүртгэсэн	1	31,209.6			1	31,209.6	1	31,209.6				
<b>Дүн</b>		<b>6</b>	<b>99,129.8</b>	<b>0</b>	<b>0.0</b>	<b>6</b>	<b>99,129.8</b>	<b>6</b>	<b>99,129.8</b>	<b>0</b>	<b>0.0</b>	<b>0</b>	<b>0.0</b>

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

№	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Өмнөх онуудад үүссэн 22 харилцагчтай холбоотой 5,783.9 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг барагдуулах арга хэмжээ аваагүй, он дамжин үлдэгдэлтэй хэвээр байж, найдваргүй авлага үүсэх эрсдэлтэй байна.	1	5,783.9			1	5,783.9				
2	Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн авлагын үлдэгдэл 14,656.8 сая төгрөг, өглөгийн үлдэгдэл 1,785.8 сая төгрөг, нийт 16,442.6 сая төгрөгийн үлдэгдлийг жилийн эцэст тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй, зөрчил давтагдсан байна.	1	16,442.6			1	16,442.6				
3	Үлэмж Эс Жи Жи катеринг ХХК-тай “Агаарын хөлгөөр зорчигчдын хоол бэлтгэн нийлүүлэх” 24/352 дугаартай гэрээг 2024 оны 9 дугаар сарын 20-ны өдөр 1 жилийн хугацаатай гэрээний хугацаа дуусгавар болж, нээлттэй тендер сонгон шалгаруулалтыг зарлаж 3 компани оролцож шаардлага хангаагүй гэж үзэж, Үлэмж Эс Жи Жи катеринг ХХК-тай 2025 оны 10 дугаар сарын 02-ны өдөр нэмэлт гэрээ байгуулахдаа бизнес ангиллын зорчигчдын хоолны бохирын угаалгын зардал, ус ундаа тээвэрлэлтийн зардлыг тооцох тооцооллыг тусгаж, хоорондын тооцоо нийлээгүй.	1	0.0					1	0.0		
4	Бараа материалын үлдэгдэлд хяналтын тооллого хийхэд ашиглалтын хугацаа нь 2021 оны 7 дугаар сард дууссан 6665 ширхэг 27.9 сая төгрөгийн өртөгтэй ликорын үлдэгдэлтэй үр ашиггүй зардал гарсан байна.	1	27.9			1	27.9				
5	Бараа материалын дансанд 10-с дээш жилийн насжилттай 17 нэр төрлийн 114.5 сая төгрөгийн, 5-10 жилийн насжилттай 18 төрлийн 42.4 сая төгрөгийн, нийт 156.8 сая төгрөгийн бараа материалын ашиглалтгүй нөөц үүсгэсэн.	1	156.8					1	156.8		
6	Өмнөх онд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 3 нэр төрлийн 114 ширхэг үндсэн хөрөнгөд тайлант хугацаанд, нийт 123.4 сая төгрөгийн элэгдэл тооцож бүртгэсэн байна.	1	123.4			1	123.4				
7	Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үлдэх өртөггүй 10,546.1 сая төгрөгийн 2960 ширхэг хөрөнгийн цаашид ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох хүсэлтийг холбогдох байгууллагад хүргүүлээгүй, ашиглалтыг сайжруулах талаар арга хэмжээ аваагүй байна.	1	0.0					1	0.0		

МИАТ ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

8	Тус байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд түүврийн аргаар хяналтын тооллого хийхэд 6.4 сая төгрөгийн үнэтэй I mac pro-27, 5.6 сая төгрөгийн үнэтэй macbook pro 13.3 inch, нийт 12.0 сая төгрөгийн үнэтэй 2 ширхэг хөрөнгийн ажлаас халагдсан албан тушаалтнаас хүлээж аваагүй байна.	1	12.0			1	12.0			
9	Тайлант оны 1-9 дүгээр сард 9 аж ахуйн нэгж байгууллага болон урлаг, соёл, спортын ажилтнууд зэрэг нийт 452 иргэний билетийн үнийг 50-100 хүртэл хувиар буюу 531.3 сая төгрөгийн хөнгөлөлт олгохдоо бартерын болон хамтран ажиллах гэрээ байгуулаагүй, үр дүнг тооцоогүй, улирал тутам тайлагнаагүй байна.	1	531.3			1	531.3			
10	Тайлант оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд баталсан орлогын төлөвлөгөө 98,167.9 сая төгрөгөөр тасарч, 32,841.3 сая төгрөгийн алдагдалтай ажилласан бөгөөд борлуулалтын орлогод ногдох бүтээгдэхүүний өртөг 4.6 хувиар өссөн нь ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна.	1	98,167.9			1	98,167.9			
11	МИАТ ТӨХК-нь баазын тээврийн хэрэгслийн 34 авто машинд GPS суулгасан 16 автомашинд GPS суулгаагүй бөгөөд эдгээр автомашинуудаас 7 авто машин нь албан тушаалын авто машин унах эрхгүй газрын захирлуудад үйлчилж байгаа бөгөөд жолоочийн замын хуудсыг өдөрт 100-140 км явснаар тогтмол бүртгэсэн, нийт 71.8 сая төгрөгийн шатахууны зардал гаргасан байна. Мөн зарим албан тушаалтнуудын хувийн автомашинд 111.4 сая төгрөгийн шатахууныг олгож үрэлгэн зардал гаргасан.	1	183.2				1	183.2		
12	Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчиж, хүлээн авалтын зардалд 4.8 сая төгрөгийг төлж, зарлагын баримтын бүрдэлгүй, үрэлгэн зарцуулсан байна.	1	4.8			1	4.8			
13	Өвлийн улиралд дуудлагын бэлэн байдлыг хангах зорилгоор 22 автомашинд 4-6 сарын хугацаатай дулаан зогсоолын гэрээ байгуулж 63.7 сая төгрөг төлснөөс 9 автомашин нэгжийн дуудлагад явдаггүй, газрын дарга нарт үйлчилдэг 9 автомашины дулаан зогсоолын төлбөрт 25.0 сая төгрөг төлж үр ашиггүй зарцуулсан.	1	25.0				1	25.0		
14	Гүйцэтгэх захирлын 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн А/52 дугаар тушаалаар ахмадын санд шилжүүлж “Монгол Улсад Нисэх хүчин үүсэж хөгжсөний түүхт 100 жилийн ойд зориулан ном эмхэтгэн гаргахад 25.0 сая төгрөг, баримтат кино бүтээхэд зориулж 40.0 сая төгрөгийг төлж, зориулалт бус, үрэлгэн зарцуулсан байна.	1	65.0			1	65.0			

МИАТ ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

15	ТӨБЗГ-ын 2024 оны 732 дугаар тогтоолоор МИАТ ТӨХК-ийн 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг, МИАТ ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 13/24 дүгээр тогтоолоор 2025 оны цалингийн санг 87,712.1 сая төгрөгөөр баталсан байна. Тайлант онд нислэг-үйлдвэрлэлийн үйл ажиллагааны ажилчдын цалинг 1,814.3 сая төгрөг, ерөнхий удирдлагын зардлын цалин 1,078.7 сая төгрөгөөр тус тус хэтрүүлж, зөрчил давтагдсан байна.	1	2,893.0			1	2,893.0				
16	ТӨБЗГ-ын 2024 оны 732 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар үйлдвэрлэлийн нэгжид зуны нислэгээр 283 түр орон тоог баталсан байна. Гүйцэтгэлээр үйлдвэрлэлийн нэгжид хамаарахгүй 11 хэлтэс, нэгжид хөдөлмөрийн гэрээ байгуулан 39 ажилтныг түр томилон ажиллуулж, нийт 832.6 сая төгрөгийн цалин олгож үр ашиггүй зардал гаргасан байна.	1	832.6			1	832.6				
<b>Дүн</b>		<b>16</b>	<b>125,249.4</b>	<b>0</b>	<b>0.0</b>	<b>11</b>	<b>124,884.4</b>	<b>5</b>	<b>365.0</b>	<b>0</b>	<b>0.0</b>

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
				Албан шаардлага		Хариуцлага тооцох албан шаардлага		Зөвлөмж			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Тус компанийн дансанд бүртгэлтэй 87-73УКК /NISSAN PATROL/, 93-59УББ /TOYOTA LAND CRUISER 200/ маркийн 2 автомашин нь цагаан болон цэнхэр өнгийн дэвсгэрт бүхий 2 янзын дугаартай байгаа бөгөөд хяналтын тооллого хийх үед цагаан өнгийн дугаартай байсан нь хөрөнгийг зориулалт бус ашиглах эрсдэлтэй байна. Мөн хөрөнгийн бүртгэлээр Бээжин хотын төлөөлөгчийн газарт үндсэн 2 ажилчинтай боловч 3 автомашин, Сөүл хотын төлөөлөгчийн газарт үндсэн 6 ажилчинтай боловч 4 автомашин, Токио хотын төлөөлөгчийн газарт үндсэн 3 ажилчинтай боловч 3 автомашин тус тус ашиглаж байгаа нь цаашид зардал нэмэгдүүлэх эрсдэлтэй байна	1	0.0	1	0.0						

МИАТ ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2	МИАТ ТӨХК-ий Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 13/24 дугаар тогтоолоор орон тооны дээд хязгаарыг баталсан, Гүйцэтгэх захирлын 2016 оны Б/784 дугаар тушаалаар компанийн хэлтэс, нэгжүүдийн бүтэц, зохион байгуулалт, орон тоог баталсанд жил бүр гүйцэтгэх захирлын тушаалаар бүтцийн өөрчлөлт оруулсан байна. Гэхдээ түр албан тушаалд нислэгийн ачаалалтай уялдаагүй, удаан хугацаагаар ажиллуулах, үйлдвэрлэлийн нэгжид бус төв оффист түр албан тушаалтан авах зэргээр орон тоо бүтцийг оновчтой зохион байгуулахгүй байгаа нь цалингийн зардлын өсөлтөд нөлөөлж байна.	1	0.0					1	0.0
3	Зорчигчийн урсгалыг нэмэгдүүлэх суудал ашиглалтыг сайжруулах зорилгоор тасалбарын үнийг хөнгөлсөн, урамшууллын хэмжээг баталсан гүйцэтгэх захирлын 12 тушаал, санхүүгийн тайланд залруулга хийхтэй холбоотой 6 тушаал, 5 сая төгрөгөөр дээш үнийн дүн бүхий 32,133.4 сая төгрөгийн худалдан авалтыг шилэн дансны цахим хуудаст байршуулаагүй, өмнөх аудитын албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.	1	32,133.4	1	32,133.4				
<b>Дүн</b>		<b>3</b>	<b>32,133.4</b>	<b>2</b>	<b>32,133.4</b>	<b>0</b>	<b>0.0</b>	<b>1</b>	<b>0.0</b>



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 955/АД160070

Улаанбаатар хот

САГ-2026/40/КА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд МИАТ ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх онуудад үүссэн 22 харилцагчтай холбоотой 5,783,905,567.00 /таван тэрбум долоон зуун наян гурван сая есөн зуун таван мянга таван зуун жаран долоон/ төгрөгийн авлагын үлдэгдлийг барагдуулах арга хэмжээ аваагүй, он дамжин үлдэгдэлтэй хэвээр байж, найдваргүй авлага үүсэх эрсдэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8-д "өр авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж тус тус заасантай нийцээгүй.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Он дамжин авлагаар бүртгэсэн насжилт өндөртэй авлагыг барагдуулах арга хэмжээ авдаггүй зөрчлийг арилгаж, 30.0 хүртэл хувиар барагдуулах талаар арга хэмжээ авах, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг МИАТ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал /Т.Тэлмэн/, Санхүүгийн удирдлагын газрын захирал /Г.Ганзул/, ахлах нягтлан бодогч /Ж.Болдбаатар/ нар т даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
В.ЭРДЭНЭЦОГТ  
Б.ДОЛГОРЖАВ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-261230

Z:\Alban Shaardlaga\2026\0325 SAG-19.Docx

1526181406



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 956/А0160070

Улаанбаатар хот

САГ-2026/40/КА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд МИАТ ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн авлагын үлдэгдэл 14,656,780,953.00 /арван дөрвөн тэрбум зургаан зуун тавин зургаан сая долоон зуун наян мянга есөн зуун тавин гурван/ төгрөг, өглөгийн үлдэгдэл 1,785,779,939.00 /Нэг тэрбум долоон зуун наян таван сая долоон зуун далан есөн мянга есөн зуун гучин есөн/ төгрөг, нийт 16,442,560,892.00 /арван зургаан тэрбум дөрвөн зуун дөчин хоёр сая таван зуун жаран мянга найман зуун ерэн хоёр/ төгрөгийн үлдэгдлийг жилийн эцэст тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй, зөрчил давтагдсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7-д "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Жилийн эцэст авлага, өглөгийн үлдэгдлийг харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг МИАТ ТӨХК-ий гүйцэтгэх захирал /Т.Тэлмэн/, Санхүү удирдлагын газрын захирал /Г.Ганзул/, ахлах нягтлан бодогч /Ж.Болдбаатар/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
В.ЭРДЭНЭЦОГТ  
Б.ДОЛГОРЖАВ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 957/A0160070

Улаанбаатар хот

САГ-2026/40/ИА -СТА-ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд МИАТ ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа материалын үлдэгдэлд хяналтын тооллого хийхэд хадгалалтын хугацаа нь 2021 оны 7 дугаар сард дууссан 6665 ширхэг 27,872,219.00 /хорин долоон сая найман зуун далан хоёр мянга хоёр зуун арван есөн/ төгрөгийн өртөгтэй ликёрын үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.2-т "төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийн эд хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах талаар санал боловсруулж төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад оруулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.4-д "төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Хугацаа нь дууссан, шаардлага хангахгүй бараа материалын нөөц үүсгэсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг МИАТ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал /Т.Тэлмэн/, Санхүү удирдлагын газрын захирал /Г.Ганзул/, ахлах нягтлан бодогч /Ж.Болдбаатар/ нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
В.ЭРДЭНЭЦОГТ  
Б.ДОЛГОРЖАВ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 958/А0160070

Улаанбаатар хот

САГ-2026/40/ИА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд МИАТ ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:


Өмнөх онд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 3 нэр төрлийн 114 ширхэг үндсэн хөрөнгөд тайлант хугацаанд, нийт 123,415,377.00 /нэг зуун хорин гурван сая дөрвөн зуун арван таван мянга гурван зуун далан долоон/ төгрөгийн элэгдлийг тооцож буруу бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "жинхэнэ хэрэгжилтийн", 5.1.4-т "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаадагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгөд элэгдэл байгуулсан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт<sup>1</sup> ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг МИАТ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал /Т.Тэлмэн/, Санхүү удирдлагын газрын захирал /Г.Ганзул/, ахлах нягтлан бодогч /Ж.Болдбаатар/ нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
В.ЭРДЭНЭЦОГТ  
Б.ДОЛГОРЖАВ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0325 SAG-19.Docx

1526181412



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 959/А0160070

Улаанбаатар хот

САГ-2026/40/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд МИАТ ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд түүврийн аргаар хяналтын тооллого хийхэд 6,399,000.00 /зургаан сая гурван зуун ерэн есөн мянган/ төгрөгийн үнэтэй I mac pro-27, 5,600,000.00 /таван сая зургаан зуун мянган/ төгрөгийн үнэтэй macbook pro 13.3 inch, нийт 11,999,000.00 /арван нэгэн сая есөн зуун ерэн есөн мянган/ төгрөгийн үнэтэй 2 ширхэг хөрөнгийг ажлаас халагдсан албан тушаалтнаас хүлээж аваагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т "эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед", 12.4-т "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллага үрэгдүүлж, дутаасан хөрөнгийн тооцоог түүний өртөг болон зах зээлийн үнийн аль өндрөөр хийнэ", 20 дугаар зүйлийн 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1-д "өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.3-т "өмч, хөрөнгийг бусдад зүй бусаар ашиглуулсан" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Ажлаас чөлөөлөгдсөн албан тушаалтантай эд хөрөнгийн тооцоог хийж, хөрөнгийг хүлээж аваагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг МИАТ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал /Г.Тэлмэн/, Санхүү удирдлагын газрын захирал /Г.Ганзул/, ахлах нягтлан бодогч /Ж.Болдбаатар/ нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

Ц.НАРАНЧИМЭГ  
В.ЭРДЭНЭЦОГТ  
Б.ДОЛГОРЖАВ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 960/А0160070

Улаанбаатар хот

САГ-2026/40/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд МИАТ ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны 1-9 дүгээр сард 9 аж ахуйн нэгж байгууллага болон урлаг, соёл, спортын ажилтнууд зэрэг нийт 452 иргэний билетний үнийг 50-100 хүртэл хувиар буюу 531,311,747.00 /таван зуун гучин нэгэн сая гурван зуун арван нэгэн мянга долоон зуун дөчин долоон/ төгрөгийн хөнгөлөлт олгохдоо бартерийн болон хамтран ажиллах гэрээ байгуулаагүй, үр дүнг тооцоогүй, улирал тутам тайлагнаагүй байна.


Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 3-т "Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын хөрөнгөөр хандив, тусламж, түүнтэй адилтгах эливаа хөтөлбөр, арга хэмжээ, нийгмийн шинжтэй үйл ажиллагаа болон төсвийн алдагдлыг санхүүжүүлэхийг хориглоно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэсэн заалтыг тус тус **ШААРДАХ нь:**

1. Хамтран ажиллах болон бартерийн гэрээ байгуулалгүй хөнгөлөлт үзүүлсэн, үр дүнг тооцоогүй зөрчлийг таслан зогсоож биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг МИАТ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал /Т.Тэлмэн/, Санхүү удирдлагын газрын захирал /Г.Ганзул/, ахлах нягтлан бодогч /Ж.Болдбаатар/ нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:



Ц.НАРАНЧИМЭГ  
В.ЭРДЭНЭЦОГТ  
Б.ДОЛГОРЖАВ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо. Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-261230

Z:\Alban Shaardlaga\2026\0325 SAG-19.Docx

1526181416



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 961/АД160070

Улаанбаатар хот

САГ-2026/40/ИА - СТА -ТӨҮГ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд МИАТ ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд баталсан орлогын төлөвлөгөө 98,167,912,545.00 /ерэн найман тэрбум нэг зуун жаран долоон сая есөн зуун арван хоёр мянга таван зуун дөчин таван/ төгрөгөөр тасарч, 32,841,300,584.00 /гучин хоёр тэрбум найман зуун дөчин нэгэн сая гурван зуун мянга таван зуун наян дөрвөн/ төгрөгийн алдагдалтай ажилласан бөгөөд борлуулалтын орлогод ногдох бүтээгдэхүүний өртөг 4.6 хувиар өссөн нь ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1.3-т "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшинд баталсан орлого тасарсан зөрчлийг таслан зогсоож, үр ашгийг нэмэгдүүлэх талаар анхаарч ажиллах, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг МИАТ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал /Т.Тэлмэн/, Санхүү удирдлагын газрын захирал /Г.Ганзул/, ахлах нягтлан бодогч /Ж.Болдбаатар/ нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
В.ЭРДЭНЭЦОГТ  
Б.ДОЛГОРЖАВ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0325 SAG-19.Docx

1526181418



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 962/АД160070

Улаанбаатар хот

САГ 2026/40/КА-СТА-ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд МИАТ ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчиж, хүлээн авалтын зардалд 4,760,000.00 /Дөрвөн сая долоон зуун жаран мянган/ төгрөгийг төлж, зарлагын баримтын бүрдэлгүй, үрэлгэн зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 01 тоот албан даалгаврын 2.6-д "Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн үрэлгэн байдал, хэрэгцээгүй худалдан авалт, гадаад томилолтыг хязгаарлаж, тансаглалыг таслан зогсоох талаар харьяа байгууллага, хуулийн этгээдийн удирдлагад үүрэг өгч, үр дүнг тооцож ажиллах" гэж тус тус заасантай нийцээгүй.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Анхан шатны бүрдэл дутуу баримтаар зарлагын гүйлгээ хийж үрэлгэн зарцуулсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг МИАТ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал /Т.Тэлмэн/, Санхүү удирдлагын газрын захирал /Г.Ганзул/, ахлах нягтлан бодогч /Ж.Болдбаатар/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
В.ЭРДЭНЭЦОГТ  
Б.ДОЛГОРЖАВ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

90С6107  
9025081411

Z:\Alban Shaardlagai\2026\0325 SAG-19.Docx

1526181420



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 963 /AD160070

Улаанбаатар хот

САГ - 2026/40/КА - СТА - ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд МИАТ ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гүйцэтгэх захирлын 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн А/52 дугаар тушаалаар ахмадын санд шилжүүлж "Монгол Улсад Нисэх хүчин үүсэж хөгжсөний түүхт 100 жилийн ойд зориулан ном эмхэтгэн гаргахад 25,000,000.00 /хорин таван сая/ төгрөг, баримтат кино бүтээхэд зориулж 40,000,000.00 /дөчин сая/ төгрөгийг төлж, зориулалт бус, үрэлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4-д "Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх", Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт "Ахмадын санг байгуулан ажиллуулах" журмын 3.4-т "Ахмадын сангийн хөрөнгийг зориулалтын бус зүйлд ашиглах, зарцуулахыг хориглоно" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Байгууллагын төсвийн хөрөнгөөр Төрийн хэмнэлтийн хуулиар хориглосон үйл ажиллагааг санхүүжүүлсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг МИАТ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал /Т.Тэлмэн/, Санхүү удирдлагын газрын захирал /Г.Ганзул/, ахлах нягтлан бодогч /Ж.Болдбаатар/ нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН.

Ц.НАРАНЧИМЭГ  
В.ЭРДЭНЭЦОГТ  
Б.ДОЛГОРЖАВ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

9006109  
ATA16027  
9025081411

Z:\Alban Shaardlaga\2026\0325 SAG-19.Docx

1526181422



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 964/АД160070

Улаанбаатар хот

САГ - 2026/40/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд МИАТ ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 732 дугаар тогтоолоор МИАТ ТӨХК-ийн 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг, МИАТ ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 13/24 дүгээр тогтоолоор 2025 оны цалингийн санг 87,712,121,640.00 /наян долоон тэрбум долоон зуун арван хоёр сая нэг зуун хорин нэгэн мянга зургаан зуун дөчин/ төгрөгөөр баталсан байна. Тайлант онд нислэг-үйлдвэрлэлийн үйл ажиллагааны ажилчдын цалинг 1,814,304,690.00 /нэг тэрбум найман зуун арван дөрвөн сая гурван зуун дөрвөн мянга зургаан зуун ерэн/ төгрөг, ерөнхий удирдлагын зардлын цалин 1,078,718,203.00 /нэг тэрбум далан найман сая долоон зуун арван найман мянга хоёр зуун гурван/ төгрөгөөр тус тус хэтрүүлж, зөрчил давтагдсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4-т "үйлдвэрийн газрын захиргааны бүтцийг тогтоож, албан тушаалтныг томилох, чөлөөлөх, эрх бүхий байгууллагаас тогтоосон цалингийн бүдүүвч сангийн хэмжээнд багтаан цалинг тогтоох", МИАТ ТӨХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.8.9-д "Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан орон тоо, зохион байгуулалтын бүтцийн хүрээнд ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг батлах, ажилтныг ажилд томилох, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, ажлаас чөлөөлөх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.5-д "төсвийн орлого, зарлагыг буруу тооцоолсон, төсөвт зардлыг хэтрүүлсэн" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

- Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд зардлыг бодитой төлөвлөөгүй, цалингийн зардлыг хэтрүүлсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг МИАТ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал /Т.Тэлмэн/, Санхүү удирдлагын газрын захирал /Г.Ганзул/, ахлах нягтлан бодогч /Ж.Болдбаатар/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
В.ЭРДЭНЭЦОГТ  
Б.ДОЛГОРЖАВ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

9006109  
ATA16007  
9025081411

Z:\Alban Shaardlaga\2026\0325 SAG-19.Docx

1526181424



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 965/АД160070

Улаанбаатар хот

САГ-2026/40/КА-СТА-ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд МИАТ ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 732 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар үйлдвэрлэлийн нэгжид зуны нислэгээр 283 түр орон тоог баталсан байна. Гүйцэтгэлээр үйлдвэрлэлийн нэгжид хамаарахгүй 11 хэлтэс, нэгжид хөдөлмөрийн гэрээ байгуулан 39 ажилтныг түр томилон ажиллуулж, нийт 832,628,335.00 /найман зуун гучин хоёр сая зургаан зуун хорин найман мянга гурван зуун гучин таван/ төгрөгийн цалин олгож, үр ашиггүй зардал гаргасан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4-т "үйлдвэрийн газрын захиргааны бүтцийг тогтоож, албан тушаалтныг томилох, чөлөөлөх, эрх бүхий байгууллагаас тогтоосон цалингийн бүдүүвч сангийн хэмжээнд багтаан цалинг тогтоох", МИАТ ТӨХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.8.9-д "Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан орон тоо, зохион байгуулалтын бүтцийн хүрээнд ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг батлах, ажилтныг ажилд томилох, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, ажлаас чөлөөлөх" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

- Батлагдсан орон тоонд байхгүй үйлдвэрлэлийн бус нэгжид түр ажилтан томилон ажиллуулсан зөрчлийг таслан зогсоох, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг МИАТ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал /Г.Тэлмэн/, Санхүү удирдлагын газрын захирал /Г.Ганзул/, ахлах нягтлан бодогч /Ж.Болдбаатар/ нар т даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
В.ЭРДЭНЭЦОГТ  
Б.ДОЛГОРЖАВ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-261230

ATA16087  
9025081411

Z:\Alban Shaardlaga\2026\0325 SAG-19.Docx

1526181426



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 966/АД160070

Улаанбаатар хот

САГ-2026/40/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд МИАТ ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус компанийн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 87-73УКС /Nissan patrol/, 93-59УБВ /Toyota land cruiser 200/ маркийн 2 автомашин нь цагаан болон цэнхэр өнгийн дэвсгэрт бүхий 2 янзын дугаартай байгаа бөгөөд хяналтын тооллого хийх үед цагаан өнгийн дугаартай байсан нь хөрөнгийг зориулалт бус ашиглах эрсдэлтэй бөгөөд хөрөнгийн бүртгэлээс үзэхэд Бээжин хотын төлөөлөгчийн газарт үндсэн 2 ажилчинтай боловч 3 автомашин, Сөүл хотын төлөөлөгчийн газарт үндсэн 6 ажилчинтай боловч 4 автомашин, Токио хотын төлөөлөгчийн газарт үндсэн 3 ажилчинтай боловч 3 автомашин тус тус ашиглаж байгаа нь хэт үрэлгэн зарцуулалттай байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн автотээврийн хэрэгсэлд бусад автотээврийн хэрэгсэлээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ", Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "үр ашигтай байх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1.3-т "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах" гэж заасантай тус тус нийцээгүй.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

- Гадаад дахь төлөөлөгчийн газруудын орон тоо, бүтэц болон тээврийн хэрэгслийн тоо, ашиглалтын хэрэгцээнд дүн шинжилгээ хийж, илүүдэл, үр ашиггүй автомашиныг татан төвлөрүүлэх, компанид бүртгэлтэй тээврийн хэрэгслийн улсын дугаарыг холбогдох хуулийн шаардлагад нийцүүлэх, зориулалтын бус дугаар ашиглаж байгаа зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх
- Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг МИАТ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал /Г.Тэлмэн/, Санхүү удирдлагын газрын захирал /Г.Ганзул/, ахлах нягтлан бодогч /Ж.Болдбаатар/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
В.ЭРДЭНЭЦОГТ  
Б.ДОЛГОРЖАВ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

9006109  
ATA16087  
9025081411

Z:\Alban Shaardlaga\2026\0325 SAГ-19.Docx

1526181428



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 967/А0160070

Улаанбаатар хот

САГ-2026/40/ИА-СТА-ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд МИАТ ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Зорчигчийн урсгалыг нэмэгдүүлэх суудал ашиглалтыг сайжруулах зорилгоор тасалбарын үнийг хөнгөлсөн, урамшууллын хэмжээг баталсан, санхүүгийн тайланд залруулга хийх зэрэг тус компанийн гүйцэтгэх захирлын 2025 оны 18 тушаал, хөрөнгө оруулалтаар 32,133,360,709.00 /гучин хоёр тэрбум нэг зуун гучин гурван сая гурван зуун жаран мянга долоон зуун есөн/ төгрөгийн таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг зэргийг шилэн дансны цахим хуудаст байршуулаагүй, зөрчил давтагдсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4-д "хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх", 6 дугаар зүйлийн 6.4.2-т "тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт", 6.4.4-д "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим хуудаст хуулийн дагуу мэдээлэл байршуулдаггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг МИАТ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал /Т.Тэлмэн/, Санхүү удирдлагын газрын захирал /Г.Ганзул/ ахлах нягтлан бодогч /Ж.Болдбаатар/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
В.ЭРДЭНЭЦОГТ  
Б.ДОЛГОРЖАВ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

9666104  
MIATCSBY  
902508141

Z:\Alban Shaardlaga\2026\0325 SAG-19.Docx

1526181430

